



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/106

Мандалговь

“Монгол Машин Индустрал” ХХК-тай  
гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/180 тоот захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Гамшгийн эрсдэлийг бууруулах нөөц” ажлын батлагдсан зардлаас Коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор явуулын постны байр нийлүүлэх ажлыг “Монгол Машин Индустрал” ХХК-тай 20,000,000 (хорин сая) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Гэрээнд заасан хугацаанд Коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор явуулын постын байр нийлүүлэхийг “Монгол Машин Индустрал” ХХК-ны гүйцэтгэх захирал (Ж.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Цагдаагийн газрын дарга (Г.Наранбаатар), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ

